



2025 оны 03 дугаар сарын 13
№12 (1357)

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
АЛБАН МЭДЭЭЛЭЛ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

64.	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай	Дугаар 109	559
65.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 112	574



ЗАКОНОДАВСТВО

558
559

560
561

ЧИГҮҮТ СҮҮГҮҮР НАСАЛСААРЫН ГҮҮГҮҮРНҮҮЛСҮҮЛСНЭЭ

562.
ХААНДЫД ТҮМСНЭЛ СҮҮГҮҮРНҮҮЛСҮҮЛСНЭЭ

563.
ХААНДЫД ТҮМСНЭЛ СҮҮГҮҮРНҮҮЛСҮҮЛСНЭЭ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хот

Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн захирагааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.

2.Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ

Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН АЛБАН
ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ ёс зүйн хэм хэмжээний зорилго нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.3-т заасан төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон эрх бүхий албан тушаалтан, улсын болон орон нутгийн төсвээс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан (цаашид "албан хаагч, албан тушаалтан" гэх)-ы Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.1-д заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтооход оршино.

1.2. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжид заасан тохиолдолд тухайн салбар, байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан албан хаагчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон энэ ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан мөрдүүлж болно.

**Хоёр. Албан хаагч, албан тушаалтны
ёс зүйн хэм хэмжээ**

2.1. Ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрднө:

2.1.1. хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх;

2.1.2. хүн, хуулийн этгээдийн асуудлыг хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэж хариу өгөх;

2.1.3. хүн, хуулийн этгээдээс хууль тогтоомжид заагаагүй нэмэлт баримт бичиг, төрийн цахим мэдээллийн санд байгаа, эсхүл төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр солилцон ашиглах боломжтой баримт бичгийг цаасан хэлбэрээр шаардахгүй байх;



2.1.4.ажлын байр, олон нийтийн газар, цахим орчин болон нийгмийн сүлжээнд төрийн албаны нэр хүндэд харшлах үйл ажиллагаанд оролцохгүй, үг, үйлдэл гаргахгүй байх;

2.1.5.хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичиг, төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, түүний хэрэгжилтийн талаарх эх сурвалжгүй, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл хийх, тараахгүй байх.

2.2.3ан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрдөнө:

2.2.1.ажлын байр, олон нийтийн газар, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа болон цахим орчин, нийгмийн сүлжээнд зүй бус үг хэрэглэхгүй, үйлдэл, зан байдал гаргахгүй байх;

2.2.2.үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний эрх болон хүн, хуулийн этгээдийн нэр төрийг хүндэтгэх, тэдэнд учирч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх;

2.2.3.албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн хүний хувийн болон эмзэг мэдээллийг хадгалах, хамгаалах.

2.3.Хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрдөнө:

2.3.1.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг биелүүлэх;

2.3.2.Төрийн болон албаны нууцын тухай хуулиар хамгаалагдсан нууцыг хадгалах, хамгаалах;

2.3.3.өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос үргэлж дээгүүр тавих;

2.3.4.албан тушаалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлаас татгалзах, хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхолтой холбогдох аливаа шийдвэр гаргахгүй байх;

2.3.5.албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдхөн хүн, хуулийн этгээдэд хууль бусаар давуу байдал олгохгүй байх, тэднээс бэлэг, хөнгөлөлттэй зээл, үйлчилгээ, бусад хангамж, ашигтай нөхцөл бүхий саналыг хүлээж авахгүй байх;

2.3.6.хууль тогтоомж зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдээлэх;

2.3.7.өөрийн болон гэр булийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээл, түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр үнэн зөв мэдүүлэх;

2.3.8.төрийн байгууллага, албан тушаалын болон албан тушаалтны нэрийг өөрт ашигтай байдал бий болгох зорилгоор ашиглахгүй байх;

2.3.9.албан хаагчийг ажил үүргээ гүйцэтгэхэд хууль бусаар нөлөөлөх, саад учруулах, хөндлөнгөөс оролцох, хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардахгүй байх;

2.3.10.төрийн байгууллагын эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж болон албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;

2.3.11.албаны хэрэгцээнд ашиглаж байгаа “хөх” өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай автотээврийн хэрэгслийг хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх;

2.3.12.төрийн байгууллагын эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгслийг стандарт болон ашиглалтын горимын дагуу зөв, гамтай, цэвэр няմбай ашиглах;

2.3.13.албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс бусад олон нийтийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцохдоо шударга, ёс зүйтэй хандах.

2.4.Албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрднө:

2.4.1.албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцах;

2.4.2.өөрийн гаргасан ажил мэргэжлийн алдаа, дутагдал, ёс зүйн зөрчлийг шударгаар хүлээн зөвшөөрөх, үйлдэлдээ дүгнэлт хийж бусдаас училалт гүйх, зохих хариуцлага хүлээх чадвартай байх.

2.5.Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн хувьд төвийг сахиж, аливаа улс төрийн эвсэл, хөдөлгөөн, намын нөлөөллөөс ангид байх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрднө:



2.5.1.албан үүргээ гүйцэтгэх хугацаандаа улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөнөөс аливаа үүрэг хүлээхгүй, нөлөөлөлд автахгүй байх;

2.5.2.өөрийн шууд удирдлагадаа байгаа албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд оролцохоос сэргийлэх.

2.6.Төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрднө:

2.6.1.хувийн үзэл бодлоос үл хамааран төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, шийдвэр болон бусад эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх;

2.6.2.төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцохгүй байх;

2.6.3.хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, нийгмийн сүлжээнд төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаатай холбоотой зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх, эх сурвалж нь тодорхой бус мэдээ, мэдээллийг өгөхгүй байх;

2.6.4.улс төрийн нөхцөл байдал, улс төрийн нам эвсэл, дайн, шашин шутлэгтэй холбоотой хувийн үзэл бодол, итгэл үнэмшлээ бусдад тулгахгүй байх.

2.7.Албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрднө:

2.7.1.албан үүргээ гүйцэтгэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрплэлтийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, улс төрийн болон хувийн үзэл бодол, эрүүл мэндийн байдал, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь ялгаварлан гадуурхахгүй байх, эрхийг нь аливаа хэлбэрээр хязгаарлахгүй байх;

2.7.2.албан үүргээ гүйцэтгэхдээ хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, хөрөнгө, орлого болон бусад байдлаар ялгавартай хандаж, шийдвэр гаргахгүй байх;

2.7.3.албан тушаалын бүрэн эрхээ ашиглан бусдад үг, үйлдэл, цахимаар болон бусад хэлбэрээр хүнд суртал, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхгүй байх;

2.7.4.бусдыг аливаа хэлбэрээр дарамталж хууль бус үйлдэл хийхэд хүргэхгүй байх;

2.7.5.албан харилцаанд нүүрний хувирал, биеийн хэлэмж, уг хэллэг, бусад байдлаар бусдыг үл тоомсорлох, тохурхан даажигнах, дорд үзэх зэрэг харилцаа, хандлага гаргахгүй байх.

2.8.Байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрднө:

2.8.1.байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг чанд баримтлах;

2.8.2.харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, уг, үйлдээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлах;

2.8.3.албан үүргээ гүйцэтгэхдээ байгууллагаас зөвшөөрсөн албаны цахим шуудан ашиглах, албан харилцаанд хувийн цахим шуудан ашиглахгүй байх;

2.8.4.албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс жаягийг баримталж, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа уг, үйлдэл гаргахгүй байх;

2.8.5.албан томилолтоор гадаад улсад зорчихдоо мөрийтэй тоглоом (казино) тоглох, энэ төрлийн үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй байх.

2.9.Албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалzan үзэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрднө:

2.9.1.албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг тооцож бодит байдал, тооцоо судалгаанд үндэслэж байх;

2.9.2.удирдах албан тушаалтныг хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах;



2.9.3.удирдах албан тушаалтны үзэл бодолд нийцэх эсэхийг үл харгалзан аливаа дүгнэлт, шийдвэрийн үр дагавар, эрсдэл, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх.

2.10.Багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрднө:

2.10.1.хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, саналын зөрүүтэй тохиолдолд бусдын үзэл бодол, итгэл үнэмшил, мэргэшсэн байдалд хүндэтгэлтэй хандах, зөрчилдөөнийг шударга, эв зүйгээр шийдвэрлэхэд манлайлал үзүүлэх;

2.10.2.хувийн үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, итгэл үнэмшлийг хүндэтгэж тэдэнд учирч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх;

2.10.3.албан харилцаанд зүй бус үг хэллэг, үйлдэл, зан байдал гаргахгүй байх, хамт олны эв нэгдэлд сөргөөр нөлөөлөх зүйлд бусдыг уриалахгүй, турхирахгүй байх;

2.10.4.хамт олны мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын гүйцэтгэлийг шударга, бодитой үнэлэх;

2.10.5.өөрийн мэдлэг, ур чадвар, туршлага, ажил хэргийн мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг хамтран ажилладаг албан хаагчидтай хуваалцах;

2.10.6.удирдах, удирдуулах зарчмыг баримталж, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнаас баталсан шийдвэр, хууль ёсны үүрэг даалгавар, шаардлагыг цаг тухайд нь мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх;

2.10.7.албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахыг цээрлэх.

----о0о----



6.5.4. Решение о выдаче гражданам документов о предоставлении им социальных услуг:

Установленный в Указе №12/1357/ от 2025 года порядок выдачи гражданам документов о предоставлении им социальных услуг включает следующие этапы:

- Предоставление гражданом заявления о предоставлении им социальной услуги;
- Рассмотрение заявления и выдача граждану соответствующего документа о предоставлении им социальной услуги;
- Выдача граждану соответствующего документа о предоставлении им социальной услуги.

Документы, выдаваемые гражданам о предоставлении им социальных услуг, должны содержать следующую информацию:

- Фамилию, имя, отчество гражданина;
- Номер документа о предоставлении им социальной услуги;
- Период действия документа;
- Назначение социальной услуги;
- Место выдачи документа;
- Инициалы лица, выдавшего документ;
- Печать или электронная подпись выдавшего документ лица.

Документы, выдаваемые гражданам о предоставлении им социальных услуг, должны быть оформлены в соответствии с установленными формами и стандартами, определенными в Указе №12/1357/ от 2025 года.

Документы, выдаваемые гражданам о предоставлении им социальных услуг, должны храниться в специальном архиве в течение не менее 5 лет с момента выдачи.

Документы, выдаваемые гражданам о предоставлении им социальных услуг, являются официальными и обязательны для применения в дальнейшем.



6. З. Ч.А. Задача 2. Найдите значение выражения $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdot \frac{1}{4} \cdots \frac{1}{n}$, если $n = 10$. Решение:

Представим выражение в виде произведения $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdot \frac{1}{4} \cdots \frac{1}{10}$. Учимся выносить общие множители за скобки. Используя свойство умножения, получим $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdot \frac{1}{4} \cdots \frac{1}{10} = \frac{1}{2} \cdot \left(\frac{1}{3} \cdot \frac{1}{4} \cdots \frac{1}{10} \right)$. Второе выражение можно представить в виде произведения $\frac{1}{3} \cdot \frac{1}{4} \cdots \frac{1}{10} = \frac{1}{4} \cdot \left(\frac{1}{5} \cdot \frac{1}{6} \cdots \frac{1}{10} \right)$. Аналогично, получим $\frac{1}{4} \cdot \left(\frac{1}{5} \cdot \frac{1}{6} \cdots \frac{1}{10} \right) = \frac{1}{5} \cdot \left(\frac{1}{6} \cdots \frac{1}{10} \right)$. Продолжая эту процедуру, получим $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdot \frac{1}{4} \cdots \frac{1}{10} = \frac{1}{10} \cdot \left(\frac{1}{11} \right)$. Тогда $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdot \frac{1}{4} \cdots \frac{1}{10} = \frac{1}{11}$.

6. Задача 3. Найдите значение выражения $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{n}$, если $n = 10$. Решение:

Представим выражение в виде произведения $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{10}$. Учимся выносить общие множители за скобки. Используя свойство умножения, получим $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{10} = \frac{1}{2} \cdot \left(\frac{1}{3} \cdots \frac{1}{10} \right)$. Второе выражение можно представить в виде произведения $\frac{1}{3} \cdots \frac{1}{10} = \frac{1}{4} \cdot \left(\frac{1}{5} \cdots \frac{1}{10} \right)$. Аналогично, получим $\frac{1}{4} \cdot \left(\frac{1}{5} \cdots \frac{1}{10} \right) = \frac{1}{5} \cdot \left(\frac{1}{6} \cdots \frac{1}{10} \right)$. Продолжая эту процедуру, получим $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{10} = \frac{1}{10} \cdot \left(\frac{1}{11} \right)$. Тогда $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{10} = \frac{1}{11}$.

6. Задача 4. Найдите значение выражения $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{n}$, если $n = 10$. Решение:

Представим выражение в виде произведения $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{10}$. Учимся выносить общие множители за скобки. Используя свойство умножения, получим $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{10} = \frac{1}{2} \cdot \left(\frac{1}{3} \cdots \frac{1}{10} \right)$. Второе выражение можно представить в виде произведения $\frac{1}{3} \cdots \frac{1}{10} = \frac{1}{4} \cdot \left(\frac{1}{5} \cdots \frac{1}{10} \right)$. Аналогично, получим $\frac{1}{4} \cdot \left(\frac{1}{5} \cdots \frac{1}{10} \right) = \frac{1}{5} \cdot \left(\frac{1}{6} \cdots \frac{1}{10} \right)$. Продолжая эту процедуру, получим $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{10} = \frac{1}{10} \cdot \left(\frac{1}{11} \right)$. Тогда $\frac{1}{2} \cdot \frac{1}{3} \cdots \frac{1}{10} = \frac{1}{11}$.

بَعْدَ سُوْلَمَةَ بَعْدَنَ وَسُوْلَمَةَ :
كَمِيْزَهَا مَلِئَ نَارَهُوْسَلَهُ تَهُوْلَهُ سَوْلَمَهُ كَمِيْزَهُ وَسَوْلَمَهُ وَسُوْلَمَهُ .
كَمِيْزَهُ سَوْلَمَهُ سَوْلَمَهُ كَمِيْزَهُ وَسَوْلَمَهُ وَسُوْلَمَهُ .

مەتەپسەرسىو . مەتەپتەسىر مەشىخىسىو . مەتەپتەسىر مەشىخىسىو . مەتەپتەسىر مەشىخىسىو .

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 112

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Газрын тухай хуулийн 18.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Аймаг дундын отрын бэлчээр ашиглах нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Отрын бүс нутаг болон аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны үйл ажиллагааны зардлыг жил бүрийн батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Отрын бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2007 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 187 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ж.ЭНХБАЯР



Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тогтоолын хавсралт

АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭР АШИГЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын тусгай хэрэгцээний зориулалтаар авсан аймаг дундын отрын бэлчээр (цаашид “отрын бэлчээр” гэх)-ийг ашиглах, хамгаалахтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Отрын бэлчээрийг ашиглах харилцаанд Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон энэ журмыг дагаж мөрднө.

1.3. Отрын бэлчээрийг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд буюу нийт 150 хоногоос хэтрүүлэхгүй ашиглана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Улсын тусгай хэрэгцээний зориулалтаар авсан аймаг дундын отрын бэлчээрийг ашиглах, хамгаалах үйл ажиллагааг Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа (цаашид “Захиргаа” гэх) хариуцаж зохион байгуулна.

2.2. Захиргаа нь улсын төсвөөс санхүүжих бөгөөд бэлчээрийг ашиглах, хамгаалах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж болно.

2.3. Захиргааны дэргэд отрын бэлчээр ашиглалтыг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын бэлчээрийн ашиглалт хариуцсан албан тушаалтан, Захиргааны дарга, тухайн бүсэд малчид нь оторлогод аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Мал эмнэлгийн газрын дарга, сумдын Засаг дарга, Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасгийн дарга нар байна. Зөвлөлийн даргаар тус отрын бэлчээрт газар нутгийн дийлэнх хувь нь харьялагдах аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга ажиллана.

2.5.Зөвлөл нь жилд хоёроос доошгүй удаа буюу жил бүрийн 06 дугаар сарын 01, 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хуралдана. Шаардлагатай бол Захиргааны хүсэлтийг үндэслэн Зөвлөлийн дарын товлосноор хуралдаж болно.

2.6.Зөвлөлийн нийт гишүүдийн ердийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцох бөгөөд хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.7.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар дүгнэлт (тэмдэглэлийн хамт) гаргана. Дүгнэлтэд Зөвлөлийн дарга болон тэмдэглэл хөтөлсөн ажилтан гарын үсэг зурж баталгаажуулна.

2.8.Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн тохиолдолд малчдаа отрын бүс нутагт оруулсан аймаг, сумаас отрын түр штабыг байгуулан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллуулж болно.

Гурав.Отрын бэлчээрийг хамгаалах, ашиглах

3.1.Захиргаа нь жил бүрийн 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс гаргасан отрын бэлчээрийн болон тухайн отрын бэлчээрт малаа оторлуулдаг сумдын бэлчээрийн даацын мэдээг нэгтгэн, холбогдох аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сум, дүүргийн Засаг дарга нарт хүргүүлнэ.

3.2.Сум, дүүргийн Засаг дарга нь отрын бэлчээрийн даацтай уялдуулан тухайн бүс нутагт оторлох малчдын саналыг хүлээн авч нэгтгэн аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар тус саналыг нэгтгэн жил бүрийн 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Захиргаанд хүргүүлнэ.

3.3.Захиргаа нь тухайн отрын бэлчээрийн даац болон оторлох хүсэлт гаргасан малчдын санал, малын тооны талаарх мэдээллийг нэгтгэн жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

3.4.Захиргаа нь Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн оторлох хүсэлт гаргасан малчин болон холбогдох сум, дүүргийн Засаг дарга нартай гуравласан гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханггуулж ажиллана.

3.5.Гуравласан гэрээнд бэлчээрийг зүй зохистой ашиглах, хог хаягдлыг цэвэрлэх, ашигласан худаг болон хашаа хорооны эвдрэл, гэмтлийг засах, мал эмнэлгийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг тухай бүр устгах, болзошгүй эрсдэл,



гал түймрээс урьдчилан сэргийлэх, ашигласан эд хөрөнгийг Захиргаанд хүлээлгэн өгөх зэрэг асуудлыг тодорхой тусгана.

3.6.Отрын бэлчээр ашиглаж байгаа малчин нь өөрийн хөрөнгөөр тусгай хэрэгцээний газарт өвөлжөө, хаваржааны хашаа, хороо, барилга байгууламж барих, худаг, уст цэг гаргах, байгалийн хадлан бэлтгэх, тариалангийн зориулалтаар газар хагалах, үйлдвэрлэлийн зориулалтаар самар, жимс, эмийн ургамал түүх, ан агнах зэрэг хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулахыг тус тус хориглоно.

Дөрөв.Аймаг, дундын отрын бэлчээр ашиглалт, хамгаалалтын талаарх холбогдох байгууллагын чиг үүрэг

4.1.Захиргаа дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.отрын бэлчээр ашиглах гуравласан гэрээний загварыг боловсруулж, Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;

4.1.2.энэ журмын 3.4-т заасан гуравласан гэрээг талуудтай байгуулж, хэрэгжилтийг хангуулах;

4.1.3.Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс гаргасан мэдээ, зөвлөмж болон байгаль, цаг уурын нөхцөл байдалтай уялдуулан оторлох хугацааг өөрчлөх эсэх саналыг Зөвлөлд хүргүүлж, шийдвэрлүүлэх;

4.1.4.отрын бэлчээрийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтын чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтан, бэлчээрийн харилцаанд оролцогчдыг мэдээллээр хангах, холбогдох мэдээллийг цахим мэдээллийн нэгдсэн санд тухай бүр оруулах;

4.1.5.аймаг дундын отрын бүс тус бүрээр отрын бэлчээр ашиглах төлөвлөгөөг 3 жил тутамд шинэчлэн боловсруулж, Зөвлөлд хүргүүлэх;

4.1.6.отрын бүс нутагт ажиллаж байгаа албан хаагчдыг шаардлагатай техник, тоног төхөөрөмж, машин, мотоцикл, байршил тогтоогч зэргээр хангах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд уламжилж, шийдвэрлүүлэх;

4.1.7.улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний отрын бэлчээрийг шинээр байгуулах асуудлыг холбогдох төрийн болон орон нутгийн байгууллагатай хамтран судалж, саналаа эрх бүхий байгууллагад уламжлах;



4.1.8.отрын бэлчээрт малын гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, ариутгал халдвартгүйлэлт хийх арга хэмжээг бүх шатны мал эмнэлгийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

4.1.9.өвөлжилт, хаваржилт хүндэрсэн болон онцгой нөхцөл үүссэн үед ашиглах зорилгоор хадлангийн талбайгаас байгалийн хадлан бэлтгэх, зөвшөөрөгдсөн талбайд ногоон тэжээл тариалах, өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх арга хэмжээ авах;

4.1.10.отрын бэлчээрийг өнжжөөх тухай Зөвлөлийн дүгнэлт, тэмдэглэл гарсан тохиолдолд отрын бус нутгийн үндсэн харьяат малчдыг өвөлжүүлж, хаваржуулах асуудлаар холбогдох сумдын Засаг дарга наратай зөвшилцэх, хамтран шийдвэрлэх;

4.1.11.Газрын тухай хуулийн 58.5-д заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутамд отрын бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгааг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

4.1.12.бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр олон улсын байгууллага, гадаадын төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх;

4.1.13.отроор өвөлжиж, хаваржиж буй малчид болон өрхийн гишүүдэд эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай хүргэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

4.1.14.аймаг дундын отрын бүсэд худаг, уст цэг гаргах, өвс тэжээлийн агуулах, саравч, малын хашаа, хороо барьж байгуулах, сэргээн засварлах, отрын бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх, бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх, мал эмнэлгийн болон мал үргүүлэг, технологийн ажил үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжилт хийх зэрэг отрын бэлчээрийн ашиглалт, хамгаалалтад шаардагдах зардлын тооцоог жил бүр гаргаж, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад тусгуулах арга хэмжээ авах;

4.1.15.улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бус нутгийн бэлчээрийн газрыг гэрчилгээжүүлэх хүсэлтийг холбогдох журмын дагуу газрын асуудал эрхэлсэн териийн захиргааны төв байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх;

4.1.16.энэ журамд заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр отрын бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөөгүй тохиолдолд



харьяалах сумын Засаг дарга, бусад холбогдох албан тушаалтантай хамтран бэлчээрийг албадан чөлөөлөх арга хэмжээ авах;

4.1.17.отрын бэлчээр ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар олон нийтэд ил тод мэдээлэх, малчдад сурталчлан таниулах.

4.2.Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1.отрын бэлчээрт оторлох малын тоог хэлэлцэн тогтоох;

4.2.2.бэлчээр ашиглах 3 жилийн төлөвлөгөөг хэлэлцэн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах;

4.2.3.отрын бэлчээрийг ашиглах гэрээний төслийг хэлэлцэн батлах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх;

4.2.4.отрын бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөх, өнжөөх, ашиглах хугацааг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэх.

4.3.Аймгийн Мал эмнэлгийн газар, сумын тасаг, гэрээт нэгж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.3.1.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.11-д заасны дагуу оторлох мал сүрэгт эмнэл зүйн үзлэг хийсэн талаарх тэмдэглэлийг өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийж баталгаажуулах;

4.3.2.отрын бэлчээрт малын халдварт болон гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх тарилга, туулгалт, ариутгал халдвартгүйтгэлийг технологийн хугацаанд хийх;

4.3.3.малын халдварт болон гоц халдварт өвчиний голомт, тархалтын судалгааг үндэслэн отрын бус нутагт хийх мал сургийн шилжилт хөдөлгөөний маршрутыг Мал эмнэлгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, өгөгдсөн чиглэлийн дагуу хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

4.3.4.халдварт болон гоц халдварт өвчин гарсан тохиолдолд голомтыг устгах, тархалтыг бууруулах ажлыг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

4.4.Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумын тасаг, Мал үргүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.4.1.отрын бэлчээрт өвөлжиж, хаваржих мал, малчин өрхийн дэлгэрэнгүй бүртгэлийг Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, энэ журмын 4.1.4-т заасан отрын мэдээллийн сантай холбох;

4.4.2.отрын бэлчээрт өвөлжиж, хаваржих малыг засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн код бүхий ээмэг, чипээр ялан тэмдэглэж, бүртгэлжүүлсэн эсэхийг нягтлах, ялгах тэмдэглэгээ хийгдээгүй малыг тухайн аймаг, сумын код бүхий ээмэг, чипээр бүртгэлжүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

4.4.3.отрын бэлчээрт өвөлжиж, хаваржих үржлийн хээлтэгч, хээлтүүлэгчийн бүртгэлийг холбогдох журмын дагуу хийж, гарал үүсэл, удам гарвалийг тодорхойлсон үржлийн бүртгэлийг хөтлөх.

Тав.Бусад

5.1.Жилийн эцсийн мал тооллогыг тухайн отрын бус нутагт малчдаа оторлуулж байгаа сумын Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулна.

5.2.Оторлож байгаа малчин өрхийн гишүүдэд нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зардлыг тухайн сумын эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан тохиолдолд сууринсан төлбөрийн аргаар тооцно.

5.3.Захиргааны дарга, албан тушаалтан болон отрын бэлчээрийг орон нутагт хариуцан ажиллах мэргэжилтэн нь энэ журамд заасан үүргээ зөрчсөн, өөрийн эрх мэдэл, албан тушаалыг ашиглан бусдад давуу эрх олгосон нь нотлогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.4.Отрын бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх болон оторлохтой холбоотой үүссэн маргаан, зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

----00----



БИСЭХ СҮГЭР ХОЛДУУГАА ХОЛДУУГАА БИСЭХ СҮГЭР ХОЛДУУГАА

ХААНШАНДЫАН ДҮЭМ

ХААНШАНДЫАН

ХААНШАНДЫАН ДҮЭМ

ХААНШАНДЫАН ДҮЭМ 96 95 94 93 92 91 90 89

Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. «Худалдааны худалдааны шийнүүдэд дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно. Тансен хамгийн дасгалд тэмдэглэж, дэвшижүүлж иштэхэндээ шийнүүдэд нийтийн мөнгөн худалдаанд хамгийн зориулахаар бий болно.

Ишнээчүүлэх
худалдааны дүн

Ишнээчүүлэх
худалдааны дүн

لِسْتَ شَرِيكًا لِّيَقْرَأُكُمْ مِّنْ كُلِّ مَا تَعْلَمُونَ
كَذَلِكَ هُنَّ مُهَاجِرُونَ مِنْ أَنفُسِهِمْ
لَا يَجِدُونَ حَلِيلًا

۶۰۰: [بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ] سُبْحَانَ اللَّهِ رَبِّ الْعَالَمِينَ وَبِحَمْدِهِ

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

5. 54-р

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

-00-

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeeel@parliament.mn

Үтас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 200003